



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ


2015 оны эхний хагас жилд

Э-Сонин

33 дахь дугаар




ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



БҮРТГЭЛТЭЙ хувьцаат компани



ГИШҮҮН үнэт цаасны компани

62

Нийт

43

Арилжаанд
оролцсон


Хамгийн өндөр арилжаа хийсэн ҮЦК

Рэнк	Үнэт цаасны компани	тэрбум төг/эзлэх %	
1	Тэнгэр Капитал ҮЦК	136.4	45.8
2	ТиДиБи Капитал ҮЦК	84.1	28.2
3	Ард Капитал групп ҮЦК	38.1	12.8
4	БиДиСек ҮЦК	15.6	5.3
5	Голомт Секюритиз ҮЦК	13.4	4.5
6	Дэу Секьюритис Монгол ҮЦК	3.1	1.0
7	Стандарт инвестмент ҮЦК	1.1	0.4
8	Алтан хоромсог ҮЦК	0.8	0.3
9	Гацуурт трейд ҮЦК	0.5	0.2
10	Монгол Секюритиес ҮЦК	0.5	0.2

ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



MSE ALL инпекс **1,025.89**
(+25.89)



1,057.86

Дээд үзүүлэлт

971.20

Дундаж үзүүлэлт

921.67

Доод үзүүлэлт

ТОП-20 индекс **15,023.81**
(+257.76)



15,737.17

Дээд үзүүлэлт

13,744.84

Дундаж үзүүлэлт

12,477.28

Доод үзүүлэлт

2014.06

2015.06

Өөрчлөлт

**НОГДОЛ
ашиг**

27 ХК
52.2 тэрбум.төг

17 ХК
6.8 тэрбум.төг

-10 ХК
-45.4 тэрбум.төг

**ХУВЬЦААНЫ
тоо ширхэг**

4,743.9 сая
2,038.5 сая

4,929.8 сая
2,210.8 сая

+185.9 сая
+172.3 сая

2,705.4 сая

Төрийн өмчит
2,719.1 сая

+13.6 сая

Хувийн өмчийн

**ХӨРӨНГӨ
оруулагчид**

6,610

11,540
Шинэ орлогч

+4,930

**ГАДААД ХО-чдын
Хийсэн гүйлгээ**

2.1
тэрбум.төг

4.0
тэрбум.төг

189.38
Дахин өссөн

**ДОТООД ХО-чдын
Хийсэн гүйлгээ**

10.7
тэрбум.төг

33.3
тэрбум.төг

309.61
Дахин өссөн

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА



Нийт арилжааны үнийн дүн

2015 он

290.6

Тэрбум.төг

2014 он

12.9

Тэрбум.төг

Өмнөх оноос **22.5** дахин өслөө.

Өдрийн дундаж гүйлгээ

2015 он	2.3 тэрбум төгрөг
2014 он	100.7 сая төгрөг

Арилжаа Явагдсан өдөр	125 /Өдөр/
--------------------------	----------------------

Арилжигдсан Үнэт цаас	19.2 /Сая ширхэг/
--------------------------	-----------------------------

Үнэт цаасны ханш		
32 өссөн	12 тогтвортой	57 буурсан

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД
ШИНЭ ТОГТОЛЦОО НЭВТЭРЛЭЭ

“MSE ALL” ИНДЕКС ЗАХ
ЗЭЭЛД НЭВТЭРЛЭЭ

МОБАЙЛ
АППЛЕКЕЙШН
ШИНЭЧЛЭГДЛЭЭ

“БИНСЭ” БОЛОН
“БИ ДИ СЕК”ХК-ИЙН
НЭМЖ ГАРГАСАН
ҮНЭТ ЦААСНЫ
АНХДАГЧ ЗАХ
ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ
ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ
ӨДӨРЛӨГ
АМЖИЛТТАЙ ЗОХИОН
БАЙГУУЛАГДЛАА



ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ШИМТГЭЛ
60 ХУВИАР БУУРЛАА

КАСТОИАНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЗАХ ЗЭЭЛД
НЭВТЭРЛЭЭ


ДААТГАГДСАН
КОМПАНИЙН БОНД ШИНЭ
БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ЗАХ
ЗЭЭЛД НЭВТРҮҮЛНЭ

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ
ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН
АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЛЭЭ

ҮНЭТ ЦААСНЫ
ТӨЛБӨР ТООЦООГ
НЭГ ХОНОГТ
ГҮЙЦЭТГЭДЭГ
БОЛЛОО

ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРГАНА

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



“MSE ALL” НЭГДСЭН ИНДЕКСИЙГ АЛБАН ЁСООР ЗАХ ЗЭЭЛД НЭВТРҮҮЛЛЭЭ

Mongolian Stock Exchange
MSE ALL
index

2015 оны 2 дугаар сарын 09-ний өдрөөс “MSE ALL” /Нэгдсэн/ индексийг албан ёсоор тооцож эхлэсэн бөгөөд нэгдсэн индексийн сагсанд МХБ дээр бүртгэлтэй, үнэт цаас нь арилжигддаг нийт 160 компанийн үнэт цаас бүгд багтах юм. MSE ALL индекс 1,000 нэгжээс тооцогдож эхлэсэн. Тус индекс нэвтэрснээр индексийн сагсан дахь компаниудын зах зээлийн үнэлгээ эрс тэс байгаагаас шалтгаалж нэгж үнэт цаасны өсөлт бууралт индекст хүчтэй савалгаа үүсгэж зах зээлийн бодит байдлыг гажуудуулж буй

явдлыг арилгах зорилгоор нэг үнэт цаасны индекст нөлөөлөх нөлөөллийг 15%-иар хязгаарлах, хаалтын ханш тогтох аргачлалыг өөрчилж тухайн арилжааны өдөр хийгдсэн бүх арилжааны тоо хэмжээний жигнэсэн дундаж ханшаар тооцоолж эхлэх нь хаалтын ханшийг бодитоор тогтоох ач холбогдолтой юм.

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЛЭЭ

3 жилийн хугацаанд завсарлаад байсан Засгийн газрын үнэт цаас 2014 оны 11 дүгээр сараас арилжигдаж эхэлсэн бөгөөд тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2015 оны 1 сарын 19 өдөр албан ёсоор эхлүүлээ. Тус үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээр зах зээлийн хөрвөх чадвар сайжирч, үнэт цаасны хүртээмж нэмэгдэж, хөрөнгө оруулагчид Засгийн газрын үнэт цаасыг өдөр бүр худалдан авах, төлбөр төлөх хугацаанаас өмнө эргүүлэн худалдах боломж бүрдсэн юм. Ингэснээр Монголын хөрөнгийн зах зээл дээрх суурь хүү /



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ




ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ШИНЭ ТОГТОЛЦОО НЭВТЭРЛЭЭ

benchmark/ болон өгөөжийн муруй /yield curve/ өрсөлдөөнт бодит горимд тогтох боломж нээгдэж эдийн засгийн чиг хандлагыг бодитоор илэрхийлэх тоон үзүүлэлт шинээр бий болох ач холбогдолтой юм.

Үнэт цаасны арилжааг идэвхжүүлж, хөрвөх чадварыг сайжруулахад мэргэжлийн дилерийн үйл ажиллагаа чухал үүрэгтэй байдаг. Хэдийгээр Монголын хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниуд нь брокер болон дилерийн давхар эрхтэй байдаг боловч ихэнх үйл ажиллагаа нь зөвхөн брокерийн буюу харилцагчийн даалгавраар үнэт цаас худалдах, худалдан авах захиалгыг биелүүлэх чиглэлээр хязгаарлагдаж байсан. Үүнээс шалтгаалж хөрөнгө оруулагч хүссэн үнэт цаасаа худалдан авч чадахгүй эсвэл өөрийн эзэмшлийн үнэт цаасаа хүссэн цагтаа зарж чадахгүйд хүрдэг бөгөөд энэ нь нийт зах зээлийн хөрвөх чадварт сөргөөр нөлөөлж ирсэн. Тиймээс Монголын хөрөнгийн биржээс 2015 оны 2 дугаар сарын 16-наас эхлэн олон улсын хөрөнгийн зах зээлийн стандарт дэд бүтэц болох “Market Makers” буюу “Итгэмжлэгдсэн дилер”-ийн тогтолцоог нэвтрүүлж, Монголын хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниудаас “БиДиСек”, “Стандарт инвестмент”, “Тэнгэр капитал” зэрэг компаниуд “Итгэмжлэгдсэн дилер”-ийн батламж авч, гэрээ байгуулсан юм.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Ингэснээр “Итгэмжлэгдсэн дилер” үнэт цаасны компаниуд Монголын хөрөнгийн биржийн арилжааны өдөр бүр Засгийн газрын үнэт цаас худалдах, худалдан авах үнийн саналыг давхар гаргаж эхлэсэн бөгөөд үнэт цаасны хүртээмж нэмэгдэж, хөрөнгө оруулагчид Засгийн газрын үнэт цаасыг өдөр бүр худалдан авах эсвэл төлбөр төлөх хугацаанаас өмнө эргүүлэн худалдах боломж нээгдэж, зах зээлийн хөрвөх чадвар нэмэгдсэн.



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ АМЖЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

2015 оны 2-р сарын 6, 7 –ны өдрүүдэд “ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ” арга хэмжээг Улаанбаатар хотод, 6-р сарын 3-ны өдөр орон нутагт /Орхон аймаг/ зохион байгуулж, олон нийт иргэдэд нэг цэгийн үйлчилгээг үзүүллээ.

Нээлттэй өдөрлөгийн хүрээнд: Иргэдийн дунд хүлээлт үүсгээд байгаа “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 1072 хувьцаа, ягаан цэнхэр тасалбарын талаар мэдээллийг өгч, иргэдийн өргөдөл гомдлыг

хүлээн авсан. Түүнчлэн аж ахуйн нэгжүүдэд зориулан хөрөнгийн зах зээлээс мөнгө босгох

боломж, хөрөнгө оруулалтын зөвлөгөөг өгч үнэт цаасны зах зээлтэй холбоотой иргэдийн сонирхсон бүх асуулт, санал хүсэлтэд үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагууд хариулт өгч ажиллаа.



2015

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



ДААТГАГДСАН КОМПАНИЙН БОНД ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ЗАХ ЗЭЭЛД НЭВТРҮҮЛНЭ

Монголын хөрөнгийн биржээс хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудын нэг болох хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх ажлын хүрээнд Барилга хот байгуулалтын яам, Монголын барилгын үндэсний ассоциаци, Монголын даатгагчдын холбоо болон Геологи, уул уурхайн мэргэжлийн институттэй хамтран ажиллаж эхлээд байгаа билээ.

Хамтын ажиллагааны эхлэл болгон талууд 2015 оны 6 сард харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Санаж бичигт талууд үнэт цаасны зах зээлд санхүүгийн шинэ хэрэгсэл буюу даатгагдсан компанийн бонд нэвтрүүлэхэд хамтран ажиллах, даатгалын нөөц сангуудад төвлөрсөн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны зах зээлд оруулах, салбарын компаниудаас IPO хийхэд МХБ-ээс мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, хөрөнгө оруулагч, харилцагчид болон салбарын мэргэжлийн байгууллагууд хооронд үр дүнтэй уулзалт, семинар, сургалтыг



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



тогтмол зохион байгуулах, Гадаадын биржид бүртгэлтэй уул уурхайн компаниудыг МХБ-д бүртгэх, арилжах, Эрдэс баялгийн салбар дахь гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдад дэмжлэг болохуйцаар хамтран ажиллах, Үнэт цаасны салбарын мэргэжлийн байгууллагууд, хөрөнгө оруулагчдад MRC Code буюу МНТ журмын талаарх сургалт, семинар зохион байгуулж байх зэрэг хамтран ажиллах үйл ажиллагааны чиглэлүүдийг тодорхойллоо. Хамтын ажиллагааны хүрээнд энэ оны 3 дугаар улиралд “Даатгагдсан компанийн бонд” санхүүгийн шинэ бүтэээгдэхүүнийг хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.

КАСТОИАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗАХ ЗЭЭЛД НЭВТЭРЛЭЭ

Монголын хөрөнгийн бирж Лондонгийн хөрөнгийн бирж групп байгуулсан стратегийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгон өөрчилж, Олон улсын хөрөнгийн зах зээлийн стандарт дэд бүтцийг Монголд нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд тус ажлын хүрээнд кастодианы үйл ажиллагаа зах зээлд шинээр нэвтрэлээ.

Худалдаа хөгжлийн банк кастодианы үйл ажиллагааг албан ёсоор 5 дугаар сараас эхлүүлээ. Монголын хөрөнгийн бирж Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтран Кастодианы үйл ажиллагааг нэвтрүүлэхтэй холбоотой ахисан шатны сургалтыг кастодиан банкны тусгай зөвшөөрөл бүхий банкнуудад зохион байгуулж, мэргэжлийн дэмжлэгийг үзүүлж ирсэн юм.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ




Кастодиан банк нь хөрөнгө оруулагчийн мөнгө, хувьцаа, бонд зэрэг үнэт цаасыг найдвартай хадгалах, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай тулгалт хийх, үнэт цаас хүлээн авах, шилжүүлэх, ногдол ашиг болон бусад орлогыг хүлээн авах, байршуулах, үнэт цаас худалдан авсан мөнгийг шилжүүлэх гэсэн үндсэн үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм.

Тус банкны үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлснээр хил дамнасан үнэт цаасны арилжаанд оролцох, мэргэжлийн хөрөнгө оруулагчид зэх зээлд нэвтрэх, дотоод руу чиглэсэн валютын урсгалыг нэмэгдүүлэх, мэдээллийн ил, тод байдал сайжрах ач холбогдолтой юм.

МОБАЙЛ АППЛЕКЕЙШНЫ 2 ДАХЬ ХУВИЛБАР “APP STORE”-Д ШИНЭЧЛЭГДЭН ТАВИГДАЖ, ХЭРЭГЛЭГДЭХЭД БЭЛЭН БОЛЛОО

Монголын хөрөнгийн бирж нь өдөр тутмын арилжааны болон ханшийн мэдээллийг түгээх гар утас болон хөдөлгөөнт төхөөрөмжид зориулагдсан мобайл апплейкешны анхны хувилбарыг 2014 оны 10 дугаар сарын 24 –ний өдөр хэрэглээнд нэвтрүүлсэн билээ. Хэрэглэгчдээс ирсэн хүсэлтийн дагуу тус програм хангамжийн 2 дахь хувилбарыг хөгжүүлэн 2015 оны 5 дугаар сарын 14 –ний өдөр “APP STORE”-д байршууллаа.


Уг шинэчилсэн хувилбар нь МХБ–ийн гишүүн үнэт цаасны компаниудын холбогдох хаяг, удирдлагын мэдээлэл, холбоо барих утас болон хаягийн мэдээллийг нэмж оруулсан бөгөөд мөн хувьцаат компаниудын үнэт цаасны ханшийн өөрчлөлтийг түүхэн графикаар харах боломжийг танд өгч байна. Шинэчилсэн хувилбар дахь график нь аль нэг брокер,



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



дилерийн компаний хувьцааны симбол дээр дарсанаар харагдах ба энэ нь хөдөлгөөнт төхөөрөмжийн хэвтээ байрлалд бүтэн дэлгэцийн горимд ажиллах чадвартай. Түүнчлэн энэхүү график нь 10 өдрөөс 5 жил хүртэл, цаашлаад бүх түүхэн мэдээллээр харагдах ба тухайн өдрийн үзүүлэлтийг муруйн дагуу даран гүйлгэх замаар хялбархан харах боломжтой юм.




“БИНСЭ” БОЛОН “БИ ДИ СЕК” ХК-ИЙН НЭМЖ ГАРГАСАН ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



“БиДиСеК” ХК-ийн 6,000,000 ширхэг нэмж гаргасан хувьцаанаас тэргүүн ээлжинд хувьцаа эзэмшигч нарт зах зээлийн үнээс хямдаар /1931 төгрөг/ худалдан авах бололцоо олгосны дагуу 1,956,625 ширхэг хувьцааг хаалттай хүрээнд худалдаж, үлдсэн 4,043,375 ширхэг хувьцааг олон нийтэд нэг бүрийг нь 2,146 төгрөгөөс доошгүй үнээр санал болгосон. Тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 2014 оны 12 дугаар сарын 26 –аас 2015 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хооронд зохион байгуулсан.

“Бинсэ” ХК /хуучнаар "Баян хайрхан" ХК/ нь 1,268,320 ширхэг хувьцааны 78.8 хувьтай тэнцэх 1,000,000 ширхэг хувьцааны нэмж гаргах хүсэлтийн дагуу СЗХ-ны 2015 оны 70 тоот тогтоолын дагууд МХБ-д бүртгэн авсан. Дээрх хувьцаанаас 200,000 ширхгийг хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу эзэмшүүлж үлдсэн 800,000 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 744 төгрөгөөр олон нийтэд

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



санал болгосон бөгөөд анхдагч зах зээлийн арилжааг 2015 оны 6 дугаар сарын 3-аас эхлүүлээд байна.

БИНСЭ

МАЛЫН ЭМ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ ТӨВ

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР
ТООЦООГ НЭГ ХОНОГТ
ГҮЙЦЭТГЭДЭГ БОЛЛОО.**

Үнэт цаасны арилжааны идэвхийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор төлбөр тооцоог гурван хоногт /T+3 / гүйцэтгэдэг байсныг өөрчилж 1 хоног болсон. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулагч үнэт цаас худалдан авсан бол маргааш гэхэд л мөнгө нь шилждэг T+1 горимд шилжиж байгаа юм.



**ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ
ШИМТГЭЛ 60 ХУВИАР
БУУРЛАА**

Монголын хөрөнгийн бирж өөрийн Электрон арилжааны системийн “Арилжааны журам”-д өөрчлөлт оруулж 2015 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржийн арилжаагаар хийгдэх хувьцааны арилжааны шимтгэлийн хувь хэмжээг гүйлгээний үнийн дүнг үл харгалзан 2015 оны 8 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл түр хугацаанд 0.15 хувь болгон бууруулсан. Энэ нь үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалт хийх зардлыг бууруулах, мэргэжлийн байгууллагууд болон хөрөнгө оруулагчдыг дэмжихэд авч буй арга хэмжээ юм.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДЫГ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРГАНА


Монголын хөрөнгийн бирж “Бүртгэлийн журам”-д өөрчлөлт оруулж, бүртгэлтэй хувьцаат компанийг 3 ангилдаг болж бизнес эрхлэгчдэд тавьдаг байсан өндөр босгыг бууруулж жижиг дунд бизнесийг Хөрөнгийн зах зээлд орох боломжийг нээсэн бөгөөд МХБ, Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудтай хамтран жижиг дунд бизнес эрхлэгчдийг Хөрөнгийн зах зээлд гаргах шат дараатай ажлуудыг энэ оны эхний хагас жилд зохион байгууллаа.



Бизнес эрхлэгчдэд Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох, үнэт цаас гаргах тухай мэргэжлийн зөвлөмж өгөх зорилго бүхий сургалт семинарыг 2 удаа зохион байгуулж, үнэт цаас гаргах сонирхол бүхий компаниудыг МХБ-ийн гишүүн андеррайтерийн компаниудтай холбож, үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг эхлүүлээд байгаа юм.



Цэвэр ашиг (алдагдал)



Үзүүлэлтүүд	2014 оны Гүйцэтгэл	2015 оны		Гүйцэтгэл хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Үндсэн үйл ажиллагааны Нийт орлого	729,928.6	1,146,288.5	762,372.7	66.5
Үндсэн үйл ажиллагааны Нийт зардал	1,686,396.7	1,141,646.8	565,116.3	49.5
Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	(956,985.3)	4,177.6	197,256.4	47.2 дахин өссөн

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК– нь сүүлийн 3 жилд нийт **2.1** тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол 2015 оны 6 дугаар сарын 30 буюу энэ оны эхний хагас жилийн байдлаар **762.3** сая төгрөгийн орлого олж, **565.2** сая төгрөгийн зардал гарган, **197.2** сая төгрөгийн үйл ажиллагааны ашигтай ажиллаж улсын төсөвт **19.8** сая төгрөгийн татвар төллөө. Мөн 2015 оны үндсэн үйл ажиллагааны ашгийг эхний хагас жилд **47.2** дахин давуулан биелүүллээ.